

“БАЯНТЭЭГ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 04 сарын 18 өдөр

Улаанбаатар хот

“Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 сарын 18-ны өдрийн 10:00 цагт Өвөрхангай аймгийн нутгийн удирдлагын ордны №203 тоотод эхлэв.

Хурлын ирц:

Хурлын дэгийн дагуу 10:10 хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга Б.Анхбилэг-н танилцуулснаар:

Компанийн 236,766 ширхэг хувьцааг эзэмшиж буй 2 хувьцаа эзэмшигч хуралд оролцож байгаа нь нийт саналын эрхтэй 252,608 ширхэг энгийн хувьцааны 93.73% болж байна. Иймд “Компанийн тухай” хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 69.2 дах заалтыг үндэслэн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов.

Хурлын дарга Ц.Идэрсайхан хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах
2. Компанийн 2024 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, үнэлэлт өгөх
3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж, батлах
4. Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай
6. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг тогтоох тухай
7. Орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-ийг “Баянтээг” ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж, батлах тухай
8. Бусад

Мөн хурлын зохион байгуулалт, хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн хуралд оролцож буй оролцогчдыг танилцуулав.

“Баянтээг” ХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Базаррагчаа компанийн 2025 оны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнгийн талаар танилцуулгыг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөлд танилцуулав.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах

“Баянтээг” ХК-ийн Ашиглалтын инженер Д.Эрдэнэбаяр Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, уулын ажлын гүйцэтгэлийн тухай мэдээллийг хуралд оролцогчдод танилцуулав.

Ерөнхий нягтлан бодогч Ю.Ариунтунгалаг компанийн өнгөрсөн оны санхүүгийн тайлан болон Төрийн Аудитын байгууллагаас ирүүлсэн “Хязгаарлалттай” дүгнэлт, түүний үндэслэл, санхүүгийн голлох үзүүлэлтүүд болон анхаарах асуудлуудын тухай мэдээлэл хүргэлээ.

ТУЗ-ийн дарга Ц.Идэрсайхан санхүүгийн тайланг санхүүгийн аудитын хороогоор оруулах талаар болон компанийн жилийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл, тодруулга, дүгнэлтийг хуралд оролцогчдод танилцуулав.

ТУЗ-ийн ердийн гишүүн С.Батсайхан компанийн санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгч буй хангалтгүй дүгнэлтийн талаар нэмэлт тайлбар, тодруулгыг хүргэж ТУЗ-ийн зүгээс гаргаж буй нэмэлт санал, санаачлагуудын талаар хувьцаа эзэмшигчдэд нэмэлт мэдээлэл хүргэв.

2. Компанийн 2024 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, үнэлэлт өгөх

“Баянтээг” ХК-ийн ерөнхий санхүүч Ю.Ариунтунгалаг компанийн 2024 хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, гүйцэтгэлийг танилцуулж тодруулга асуултуудад бүрэн мэдээлэл, хариулт өгөв.

Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар санал солилцож, санал зөвлөмжөө илэрхийллээ.

3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж, батлах

“Баянтээг” ХК-ийн Ашиглалтын инженер Д.Эрдэнэбаяр компанийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар дэлгэрэнгүй танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн зүгээс компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөөлөлтэй холбоотой асууж тодруулах зүйлсийг тодруулж, үйл ажиллагатай холбоотой асуудлуудыг хэлэлцэж, саналаа илэрхийлэв.

Хуралд оролцож буй төлөөлөгчдийн зүгээс Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд холбогдох санал, зөвлөмжийг өгч, 2025 оны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлав.

4. Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

“Баянтээг” ХК-ийн ТУЗ-ийн дарга Ц.Идэрсайхан компанийн 2024 оны санхүүгийн тайлангаар компанийн санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байх тухай ТУЗ-ийн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өөр санал, тодруулга байхгүй.

5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох

Хурлын дарга Ц.Идэрсайхан компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг дахин сонгохтой холбоотойгоор ТУЗ-ийн

нэр дэвшүүлэх хороонд хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх хүсэлт ирүүлсэн нэр дэвшигчдийг болон ердийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулж, мэдээлэл хүргэв. Нэр дэвшигчдийн мэдээлэл:

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

- Ц.Идэрсайхан
- Б.Мөнхбат
- Ц.Болдбаатар
- Ю.Батсайхан
- Б.Ичинноров
- Д.Миеэгомбо

Хараат бус гишүүнд нэр дэвшигч

- Ж.Дорждагва
- Ц.Оюун
- Ц.Нямдаш

Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тус асуудалтай холбоотой гарах тогтоолын төслийг хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

6. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг тогтоох тухай

Хурлын дарга Ц.Идэрсайхан хурлын дэгийн дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны цалин урамшуулал, зардлын төсвийг танилцуулж, цалингийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тогтоох тухай хурал танилцууллаа.

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс аливаа санал, тодруулга байхгүй.

7. Орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-ийг “Баянтээг” ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж, батлах тухай

Хулын дарга Ц.Идэрсайхан Орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-ийг “Баянтээг” ХК-тай нэгтгэх тухай асуудлыг танилцуулж, үйлдвэр бүрэн ашиглалтад ороогүй, улсын комисс хүлээж аваагүй нөхцөл байдалтай байгаа тухай мэдээлэл хүргэв.

Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн зүгээс нөхцөл байдлын тухай зарим нэмэлт мэдээллүүдийг тодруулж, хариулт авлаа.

8. Бусад асуудал

Бусад асуудлыг хэлэлцэх тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал, саналын хуудсанд тусгасан боловч дээрхтэй холбоотой ямарваа нэгэн асуудал хэлэлцүүлээгүй тул санал аваагүй.

Санал хураалт:

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцүүлсний дараа тооллогын комиссын дарга Б.Анхбилэг санал хураалт эхэлж буйг мэдэгдэж, хэлэлцэж байгаа нийт 8 асуудлын 7-д нь ердийн аргаар, 1 асуудал буюу ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудалд кумулятив аргаар санал хураахыг дурдав.

Санал хураалт явагдаж дуусав.

Тооллогын комиссын дарга Б.Анхбилэг санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах

Зөвшөөрсөн – 236,766 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

2. Компанийн 2024 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, үнэлэлт өгөх

Зөвшөөрсөн – 236,766 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

3. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэж, батлах

Зөвшөөрсөн – 236,766 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

4. Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Зөвшөөрсөн – 236,766 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

5. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг тогтоох тухай

Зөвшөөрсөн – 236,766 ширхэг хувьцаа буюу 100%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

6. Орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-ийг “Баянтээг” ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж, батлах тухай

Зөвшөөрсөн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Татгалзсан – 59,941 ширхэг хувьцаа буюу 25.32%

Түдгэлзсэн – 176,825 ширхэг хувьцаа буюу 74.68%

7. Бусад

Зөвшөөрсөн – 0 ширхэг хувьцаа буюу 0%

Татгалзсан - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн - 0 ширхэг хувьцаа буюу 0%

Хурлаар дараах асуудлыг кумулятив аргаар санал хураан шийдвэрлэв.

8. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох тухай

Саналын хуудсаар “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын дүн:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ц.Идэрсайхан	11.111%	236,766
2	Б.Мөнхбат	11.111%	236,766
3	Ц.Болдбаатар	11.111%	236,766
4	Ю. Батсайхан	11.111%	236,766
5	Б.Ичинноров	11.111%	236,766
6	Д. Миеэгомбо	11.111%	236,766

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Ж.Дорждагва	11.111%	236,766
2	Ц.Оюун	11.111%	236,766
3	Ц.Нямдаш	11.111%	236,766

тус тус санал авч эдгээр гишүүд ТУЗ-ийн гишүүдэд сонгогдов.

Хурлын шийдвэр:

- Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг танилцуулах
 - “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд өгсөн “Хангалттай” дүгнэлт, санхүүгийн тайлан, үр дүнд өгсөн “Хангалтгүй” дүгнэлт болон түүний үндэслэл, нэмэлт саналын талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсныг тэмдэглэж, баталсугай.
 - “Баянтээг” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийн дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Ц.Базаррагчаа, Ерөнхий санхүүч Ю.Ариунтунгалаг нарт даалгасугай.

2. Компанийн 2024 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, үнэлэлт өгөх
 - 2.1 "Баянтээг" ХК-ийн 2024 оны Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалттай гэж үзсүгэй.
 - 2.2 Төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан санал, зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
 3. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай:
 - 3.1 "Баянтээг" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас баталсан 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлснийг тэмдэглэж, баталсугай.
 - 3.2 Батлагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
 4. Компанийн 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
 - 4.1. "Баянтээг" ХК-ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд зохистой харьцааг хангахгүй байгаа тул 2024 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг хуралд танилцуулсныг дурдсугай
 - 4.2. 2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байх тухай шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигчдэд зохих мэдээллийг хүргэж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлд даалгасугай.
 5. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгох
 1. "Баянтээг" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:
 1. Ц.Идэрсайхан
 2. Б.Мөнхбат
 3. Ц.Болдбаатар
 4. Ю.Батсайхан
 5. Б.Ичинноров
 6. Д.Миегомбо
 2. "Баянтээг" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:
 1. Ж.Дорждагва
 2. Ц.Оюун
 3. Ц.Нямдаш нарыг тус тус
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай
6. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллыг тогтоох тухай
 - 6.1. "Баянтээг" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгох цалин, урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.

- 6.2. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдэд олгох цалин, урамшууллыг тогтоосон хэмжээгээр тооцон олгож байхыг Ерөнхий санхүүч (Ю.Ариунтунгалаг)-д даалгасугай
7. Орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-ийг “Баянтээг” ХК-тай нэгтгэх асуудлыг хэлэлцэж, батлах тухай
- 7.1 “Баянтээг” ХК-д орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-г нэгтгэх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлснийг тэмдэглэсүгэй.
- 7.2 “Баянтээг” ХК-д орон нутгийн өмчит “Баянтээг түлш” ХХК-г нэгтгэх тухай асуудлыг түр хугацаанд түдгэлзүүлж, бусад боломжит хувилбаруудын талаар судалж, танилцуулахыг Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

Хурлын дарга хурлыг хааж үг хэлснээр хурал 12:50 минутад дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:



/Б.Анхбилэг/

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Тэмдэглэл хянасан:



/Ц. Идэрсайхан/

Хурал даргалагч